МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 10 сарын 09 өдөр Дугаар 44 Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын үүргийг хавсран гүйцэтгүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2 дахь хэсэг, "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.5.4 дэх заалт, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1.4 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гүйцэтгэх захирлыг томилогдох хүртэл хугацаанд Гүйцэтгэх захирлын үүргийг Захиргаа, санхүүгийн газрын захирал Х.Эрдэнэбүрэнгээр хавсран гүйцэтгүүлсүгэй.

2.Гүйцэтгэх захирлын үүргийг хавсран гүйцэтгэхдээ холбогдох дүрэм, журамд заасны дагуу тус албан тушаалын хүрээнд гүйцэтгэх ажил, үүргийг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж ажиллахыг Захиргаа, санхүүгийн газрын захирал Х.Эрдэнэбүрэнд үүрэг болгосугай.

3.Х.Эрдэнэбүрэнд хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг түүний үндсэн цалингийн 40 хувиар тооцон олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Нарангэрэл/-д зөвшөөрсүгэй.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нэр дэвшүүлэх хороо (П.Баяр)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ш.БАТ-ЭРДЭНЭ

Монголын Хөрөнгийн Бирж УХА 0163 ТУЗ

1526010128